



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 4/53

Хэрлэн сум

Вакцинжуулах ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 29.1.6-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дорнод аймгийн Халхгол, Матад суманд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний эрсдэл өндөр байгааг харгалзан мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгаж тус аймагтай хил залгаа Баян-Овоо сумын мэдрэмтгий бүх малыг вакцинжуулах ажлыг зохион байгуулсугай.

2. Вакцинжуулалтын ажилд багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон түргэн шуурхай, чанартай зохион байгуулж ажиллахыг сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж, тарилгын дүн, санхүүжилтийн баримт материалыг холбогдох яаманд хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, вакцинжуулалтын чанар, явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА